



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 4/525


Улаанбаатар хот

Ээлжийн амралтын тооцоо хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.9 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын зайлшгүй шаардлагаар 2020 оны ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй болон амралтаа дутуу эдэлсэн хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдад 1,5 сарын цалинтай тэнцэх мөнгөн урамшил олгосугай.
2. Мөнгөн урамшлыг зохих сангаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2020

115060001357